

## **АЙМГИЙН ХҮН АМ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ 2013 ОНД**

**I. ӨРХ, ХҮН АМ:** Оны эцэст 16.4 мянган өрх, 56.3 мянган суурин хүн амтай болж, урьд оноос өрх 429-өөр, хүн ам 699-өөр өслөө. Нийт өрхийн 45.9 хувь буюу хүн амын 47.4 хувь нь хөдөөд амьдарч байна. Нийт өрхийн 29.2 хувь нь байшинд амьдарч байгаа бөгөөд урьд оноос 0.3 пунктээр өслөө. Төвлөрсөн халаалттай орон сууцанд 1463 өрх амьдарч байгаа нь урьд оноос 141 өрхөөр өссөн байна.

Хүн амын 49.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийт хүн амын 66.0 хувийг 15-59 насныхан, 28.4 хувийг 0-14 насныхан, 5.6 хувийг 60 ба дээш насныхан эзлэх болсноор хүн ам зүйн ачаалал 51.4 хувьтай болж, хөдөлмөрийн насны 2 хүнд 1 тэжээлгэгч хүн ногдож байна.

Аймгийн хэмжээний 67 багаас Баруун-Урт сумын 5-р баг 973 өрх, 3231 хүнээр тэргүүлж байна.

2013 онд 778 хүн шилжин ирсэн нь өнгөрсөн оноос 414 хүнээр өссөн байна. 1113 хүн шилжин явсан нь урьд оноос 366 хүнээр өссөн байна. Үүнээс үзэхэд шилжин ирэгсэд нь явсан хүнээсээ 48-өөр олон байгаа нь сайн үзүүлэлт юм. Шилжин явагсдын 63.9 хувь нь Улаанбаатар хот руу шилжжээ.

**II. ТӨСӨВ:** Аймгийн төсвийн орлогод 52.5 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө 2.5 хувиар давж биелсэн нь өмнөх оныхоос 39.7 тэрбум төгрөгөөр дээгүүр байна.

Баруун-Урт сумдаас бусад сумд төсвийн орлогын төлөвлөгөөгөө давуулан биелүүлсний дотор Түмэнцогт сум 5,9 дахин 725,2 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Орон нутгийн төсвийн зарлага 44.4 тэрбум төгрөг болжээ. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт 6.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

**III. МӨНГӨ, ЗЭЭЛ:** Монгол банкны мэдээгээр Арилжааны банкуудын ААНБ, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 73.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оныхоос 26.5 тэрбум төгрөгөөр буюу 56.5 хувиар өсчээ.

Иргэдийн төгрөгийн хадгаламжийн үлдэгдэл 33.2 тэрбум төгрөг болж, өмнөх оныхоос 7.9 тэрбум төгрөгөөр буюу 31.3 хувиар өссөн байна.

**IV. ХӨДӨӨ АЖ АХУЙ:** Малтай болон малчин өрх, малчид: Аймгийн нийт өрхийн 55.8 хувь болох 9.2 мянган өрх аминдаа 2468.2 мянган мал тоолуулсан нь нийт малын 99.1 хувийг эзэлж байна. 6466 малчин өрхөд 13.7 мянган малчид ажиллаж байна.

Нийт малтай өрхийн 55.2 хувийг 200 хүртэл малтай өрх эзлэх болж жил дараалан буурч, харин 200-аас дээш малтай өрхийн тоо жил дараалан өсч, чанарын өөрчлөлт гарч байна. 382 өрх мянгаас дээш мал тоолуулж, шинээр 120 мянгат малчин төрлөө.

**Мал аж ахуй:** Мал сүрэг урьд оноос 210.8 мянгаар өсч, 2.5 сая мал тоологдсны дотор тэмээ 8.9 мянга, адуу 203.1 мянга, үхэр 172.0 мянга, хонь 1216.6 мянга, ямаа 890.8 мянга болж, тэмээнээс бусад 4 төрөл дээрээ өслөө.

Эрдэнэцагаан сумаас бусад сум малаа өсгөсний дотор Сүхбаатар сум 5 төрөл дээр, бусад бүх сумд 2-4 төрөл дээр нь өсгөсөн байна. Аймгийн хэмжээнд Баяндэлгэр сум 330,3 мянган мал тоолуулж малын тоогоор тэргүүлж байгаагийн зэрэгцээ малын төрлөөр авч үзвэл: Баяндэлгэр сум 21.8 мянган үхэр, 160.0 мянган хонь, 116.7 мянган ямаагаар, Сүхбаатар сум 1.3 мянган тэмээгээр, Эрдэнэцагаан сум 27.3 мянган адуугаар аймагтаа тэргүүлж байна. Малын тоог багаар авч үзвэл: Баруун-Урт сумын 8-р баг 109.6 мянган малаар тэргүүлж байна.

Нийт 1.1 сая хээлтэгч тоологдсон нь нийт малын 43.7 хувийг эзэлж байна.

Оны эхний эх малын 86.3 хувь буюу 857.6 мянга нь төллөж, 853.3 мянган төл бойжуулж авлаа.

Оны эхний малын 1.1 хувь болох 26.0 мянган том мал зүй бусаар хорогдсон нь урьд оноос 24.2 хувиар өссөн байна.

**Газар тариалан:** Энэ онд үр тариа 300 га-д, төмс 66.9 га-д, хүнсний ногоо 25.1 га-д, тэжээлийн ургамал 38.7 га-д, техникийн ургамал 5 га-д тариалж, 430 тн үр тариа, 709.8 тн төмс, 272.7 тн хүнсний ногоо, 40.5 тн тэжээлийн ургамал, 20 тн техникийн ургамал хураасан нь урьд оноос төмс 3.9 хувиар, хүнсний ногоо 22.2 хувиар тус тус дээгүүр байна.

Хадлан 11.9 мянган.тн, гар тэжээл 657.5 тн тус тус бэлтгэсэн нь урьд оноос хадлан 1.6 хжвиар өссөн, гар тэжээл 10.1 буурсан байна.

**V. АЖ ҮЙЛДВЭР:** Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 2005 оны зэрэгцүүлэх үнээр 28.7 тэрбум төгрөг болсон нь өмнөх оноос 4.6 тэрбум буюу 13.9 хувиар буурлаа.

Аж үйлдвэрийн нийт борлуулалт 109.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 34.0 тэрбум төгрөг буюу 23.6 хувиар доогуур гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлөөс блок, замын хавтан, бордиур, тоосго, хайрга, яндан, шургуулга, түлээний авдар, түмпэн, хогийн сав, савар, гурлын сав, угаалтуур, галын хайч, агааржуулагч, хаалт, жигнүүр, усны тэрэг, дээл, ууж, хүрэм, баривч, өлгий, даалин, халаад, сандал, хаалга, ширээ, гал тогооны ком, шкаф, авдар, тэмээн тэрэг, морин хуур зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт өсч, шинээр 20-иод нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн.

**VI. БАРИЛГА, ТЭЭВЭР, ХОЛБОО:** Барилга: Нийт 19.8 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийсэн нь урьд оноос 39.0 хувиар өссөн байна.

**Тээвэр:** Тээвэр бүхий байгууллагууд 221.8 мян.тн ачаа, давхардсан тоогоор 52.6 мян. хүн тээвэрлэж, ачаа эргэлт 82.8 сая.тн км, зорчигч эргэлт 37.4 сая хүн км-т хүрсэн байна Тээсэн ачаа өнгөрсөн оноос 0.7 мян.тн буюу 1.0 хувиар өсчээ. 8.5 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оноос 1.0 хувиар өссөн байна.

**Тээврийн хэрэгслийн тооллогын дүнгээр** 7206 тээврийн хэрэгсэл үзлэг тооллогод хамрагдсан нь урьд оноос 10.1 хувиар өссөн байна. Тээврийн хэрэгслийг төрлөөр нь авч үзвэл: 80.7хувь буюу 16.8 мянга нь автомашин, 16.8 хувь буюу 1.2 мянга нь мотоцикль, 1.5 хувь буюу 1.1 мянган нь чиргүүл 0.9 хувь буюу 0.7 мянган нь механизм байна.

**Холбоо:** Холбоо ашиглалтын орлого 484.0 сая төгрөг болсны дотор хүн амаас 188.0 сая төгрөг орсон нь урьд оноос нийт орлого 0.9 хувиар , хүн амаас орох орлого 15.7 хувиар тус тус буурсан байна. Харин телефон цэгийн тоо 5.6 хувиар өссөн байна.

**VII. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС:** Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифын ерөнхий индекс урьд оны 12 сарынхаас 10.1 хувиар өссөний дотор холбооны үнэ тарифаас бусад бүх бүлгийн үнэ тариф өссөн байна. Тухайлбал: Жимс, жимсгэнэ 32.1 хувь, согтууруулах бус ундаа 18.1 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис 15.2 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 23.6 хувь, хүнсний бараа 11.8 хувь, хувцас, бөс бараа гутал 10.9 хувь, гэр ахуйн тавилга, бараа 16.3 хувь, боловсролын үйлчилгээ 30.0 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр байна.

**VIII. БОЛОВСРОЛ,СОЁЛ:** 2013-2014 оны хичээлийн жилд 355 бүлэгт 9.8 мянган хүүхэд суралцаж байгаагийн 49.6 хувь нь эмэгтэй сурагчид байна.

1-р ангид 1015 хүүхэд элсэн орж, бага ангид 4.7 мянга, дунд ангид 3.4 мянга, ахлах ангид 1.7 мянган хүүхэд тус тус суралцаж байна.

Энэ жил 17 сургуульд 958 хүн ажиллаж байгаагийн 695 буюу 72.5 хувь нь эмэгтэй хүмүүс ажиллаж байна.

ЕБС-ийн нийт ажиллагсадын дотор үндсэн багшийн эзлэх хувь аймгийн дүнгээр 53.8 хувьтай байгаагийн дотор 2, 4-р бүрэн дунд сургуульд 65.7-82.0 хувь нь үндсэн багш нар байна.

**Соёл:** Хөгжимт жүжгийн театр 2013 онд 23 мянган үзэгчдэд 46 тоглолтоор үйлчилж 20.8 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

**Музей:** 2.0 мянган үзмэрээр 1.9 мянган хүнд үйлчилж, 1.2 сая төгрөгийн орлого олжээ.

**Нийтийн номын сан:** 30,0 мянган уншигчдад 44.5 мянган номоор үйлчилж 102.5 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна.

**IX. ЭРҮҮЛ МЭНД:** 1217 эх амаржиж, 1224 хүүхэд төрсөн бөгөөд 1-5 хүртэлх насандаа 7 хүүхэд эндсэн нь урьд оноос 2-аар олон байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид 1002 болж, урьд оноос 287-оор өссөний дотор гахайн хавдар, тэмбүү, трихоминиаз, салхин цэцэг, сүрьеэ, заг зэрэг өвчлөлтүүд өссөн байна.

**X. АЖИЛГҮЙЧҮҮД:** Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 763 болж, өмнөх оныхоос 17-оор буурчээ. Ажилгүй иргэдийн 60.8 хувь нь 15-34 насны залуучууд, 39.1 хувь нь бүрэн дунд, 25.6 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна. 3250 хүн шинээр бүртгүүлж, 1764 хүн ажилд орсны дотор 885 нь шинэ ажлын байр байна.

**XI. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ:** Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 9.0 тэрбум төгрөгт хүрсэн байна. Сайн дурын даатгалын шимтгэлийн орлогод 0.3 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө 56.0 хувиар давж биелсэн.

6711 өндөр настанд 14.4 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон байна. Нийгмийн халамжийн сангаас 3.0 тэрбум төгрөгийг 5.6 мянган иргэнд, улсын төсвөөс 1.5 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 6.9 мянган иргэнд тус тус олгосны дотор хүний хөгжил сангаас 79.6 сая төгрөгийг 85 иргэнд олгосон байна.

**XII. ГЭМТ ХЭРЭГ:** Энэ онд 312 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оноос 51 хэргээр өссөн байна. Гэмт хэргийн улмаас 37 хүн нас барж, 137 хүн гэмтэж, ААНБ, иргэдэд 594.4 сая төгрөгийн хохирол учирсны 430.9 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 327 хүн сэжиглэгдсэний 25.1 хувь нь бүлэглэнгээр, 33.6 хувь нь согтуугаар хэрэг үйлджээ. Нийт 2840 хүн эрүүлжигдсэн нь урьд оноос 255 хүнээр буурчээ.

**XIII. ТӨСӨЛ:** Малын индексжүүлсэн даатгал төсөл 13 суманд хэрэгжиж 629 өрхийг хамруулж 71.2 сая төгрөгийн хураамж авсан нь урьд оноос өрхийн тоо 6.6 хувиар буюу 39 өрхөөр өсч харин хураамж 15.1 хувиар буюу 12.7 сая төгрөгөөр буурсан байна.

Сум хөгжүүлэх сангаас 218 төсөлд 1.9 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна.

**XIV. ГАЗАР ӨМЧЛӨЛ:** Нийт өссөн дүнгээр 8375 иргэн газар өмчилж авахаар өргөдөл гаргаснаас 7522 иргэнд 681.59 га газар өмчлүүлэх шийдвэр гарсан байна. Үүнээс: 2013 онд 1489 иргэн өргөдөл гаргаж, 965 иргэнд 69.43 га газрыг өмчлүүлэх шийдвэр гарчээ.

**XV. ДААТГАЛ:** Даатгалын компаниуд 21.8 мянган иргэнийг 12 төрлийн даатгалд хамруулан 334.7 сая төгрөгийн хураамжийн орлого оруулсан бөгөөд 551 иргэнд 70.7 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна.



АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН

ДАРГА

Т.ЭРДЭНЭБАТ